

Завхан аймгийн Түдэвтэй, Говь-Алтай аймгийн Чандмань, Архангай аймгийн Тариат сумдын Эрүүл мэндийн төвүүдэд эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх, Говь-Алтай аймгийн Чандмань сумын ЕБС-д эрүүл мэндийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлэх нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтын өгөгдөл

Японы Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхээ эдэлдэг ертөнцийг бий болгох алсын хараатай, хүүхдэд эерэг нөлөө үзүүлж, тэдний амьдралд урт хугацааны өөрчлөлт авчрах эрхэм зорилготой хүүхдийн төлөөх ажил үйлсээрээ тэргүүлэгч, шашин, улс төрөөс ангид олон улсын бие даасан байгууллага бөгөөд олон улсад 1919 оноос, Монгол улсад 1994 оноос хойш үйл ажиллагаа явуулж, боловсрол, эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал болон хүмүүнлэгийн яаралтай тусламж үзүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Та бүхэн Хүүхдийг Ивээх Сангийн үйл ажиллагаа, бидний хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд, манай байгууллагын бодлого журмын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <https://www.savethechildren.mn/> хаягаар орж танилцаарай.

Хүүхдийг Ивээх Сан АНУ-д төвтэй “Денан төсөл”-ийн санхүүжилтээр эрүүл мэндийн төслийг Архангай аймгийн Тариат суманд 2012 оноос, Эрдэнэмандал суманд 2017 оноос, Говь-Алтай аймгийн Чандмань суманд 2022 оноос, Завхан аймгийн Түдэвтэй суманд 2024 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна. “Денан төсөл”-ийн санхүүжилтээр сумын эрүүл мэндийн төвүүдийн үйлчилгээг сайжруулах, аймгийн жишиг эрүүл мэндийн төв болгох, зорилтот сумдын нийгмийн эрүүл мэндийг дээшлүүлэх, түүнчлэн эмнэлгийн хүний нөөцийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эмчилгээний материалаар хангах зорилготой юм.

Денан төслийн хүрээнд Завхан аймгийн Түдэвтэй, Говь-Алтай аймгийн Чандмань, Архангай аймгийн Тариат сумдын Эрүүл мэндийн төвүүдэд эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх, Говь-Алтай аймгийн Чандмань сумын ЕБС-д эрүүл мэндийн сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлэх нийлүүлэгчийн сонгон шалгаруулна.

БҮЛЭГ 1. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДӨЛ

№	1. Ерөнхий зүйл
1	Захиалагч нь: Японы Хүүхдийг Ивээх Сан (ХИС)
2	<p>Сонгон шалгаруулалтын нэр: Завхан аймгийн Түдэвтэй, Говь-Алтай аймгийн Чандмань, Архангай аймгийн Тариат сумдын Эрүүл мэндийн төвүүдэд эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх, Говь-Алтай аймгийн Чандмань сумын ЕБС-д эрүүл мэндийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлэх нийлүүлэгчийн сонгон шалгаруулалт.</p> <p>Сонгон шалгаруулалтын багцын талаарх мэдээлэл: <i>Багцаас сонгож оролцох боломжтой.</i></p> <p>Багц 1. Говь-Алтай аймгийн Чандмань сумын эрүүл мэндийн төвд мобайл технологийн аппарат, тоног төхөөрөмжийн иж бүрдэл, сумын ЕБС-н эрүүл мэндийн хичээлийн хэрэглэгдэхүүн нийлүүлэх</p> <p>Багц 2. Завхан аймгийн Түдэвтэй сумын Эрүүл мэндийн төвд иж бүрэн шүдний кабинет техник хэрэгслийн хамт нийлүүлэх</p>

	Багц 3. Архангай аймгийн Тариат сумын эрүүл мэндийн төвд хагас автомат биохимийн анализатор нийлүүлэх.
3	Санхүүжилтийн эх үүсвэр нь: АНУ-н ДЕНАН төсөл
4	Сонгон шалгаруулалтад оролцогч ерөнхий нөхцөлийг хангасан тухай Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
5	Сонгон шалгаруулалтад баталгаа ирүүлэх эсэх: Шаардахгүй.
6	Татвар хураамж: Тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл импортлох, нийлүүлэх, суурилуулах, сургалттай холбоотой гарах бүх татвар, хураамж, шимтгэлийг санал болгож буй үнэд багтаан ирүүлнэ.
7	Улсын бүртгэлийн гэрчилгээ: Шаардана. Нотариатаар батлуулсан хуулбар ирүүлэх.
8	Тусгай зөвшөөрөл: Шаардана. Эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, гэрчилгээ. Нотариатаар батлуулсан хуулбар ирүүлэх.
9	Итгэмжлэл: Оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээдийн итгэмжлэлийг Маягт 2-ын дагуу ирүүлнэ.
10	Санхүүгийн тайлан: Шаардана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2023 оны жилийн эцсийн тайлан аудитын дүгнэлтийн хамт, 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг ирүүлнэ.
11	Тухайн багцад нийлүүлэх тоног төхөөрөмжүүдийг нийлүүлж байсан гэрээний туршлага: Шаардана. Сүүлийн 2 жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалтыг гэрээ, гэрээ дүгнэсэн акт, тодорхойлолт, гэх мэт нотлох баримтын хамт ирүүлнэ. Маягт 3
12	Оролцогч дараах нэмэлт материалуудыг өөрийн үнийн саналд хамт ирүүлнэ. Үүнд: Байгууллагын танилцуулга (Хүний нөөцийн мэдээлэл, бүтээгдэхүүн нийлүүлэх, суурилуулалт хийх, сургалт зохион байгуулахад шаардлагатай хүчин чадлын мэдээлэл) Захиалагчийн зүгээс тухайн сонгон шалгаруулалтад оролцогчийн талаар харилцагч банк, харьяа татвар, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, нийгмийн даатгалын хэлтэс болон бусад байгууллагад хандаж лавлагаа, тодруулга шаардахад татгалзахгүй тухай <u>зөвшөөрсөн албан бичиг</u> ирүүлнэ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт: Шаардана. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн өдрөөс ажлын 3 өдрийн өмнө авсан байх.
13	Баталгаат хугацааны талаар мэдээлэл: Шаардана. Тоног төхөөрөмж, шаардлагатай техник хэрэгсэл тус бүр дээр баталгаат хугацаа болон нөхцөлийн талаар мэдээлэл ирүүлнэ.
2. Сонгон шалгаруулалтын баримт бичиг	
1	Санал хүлээн авах захиалагчийн хаяг: Японы Хүүхдийг Ивээх сан Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төв, 4-р давхарт. Лавлах утас: 976-11-329365-131 Сонгон шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор санал ирүүлэхдээ дугуйны гадна <u>нэр, ялгах дугаар, багцыг</u> гаргацтай тэмдэглэнэ. Мөн оролцогч нэр хаяг, утсаа тодорхой бичнэ.
2	Санал хүлээн авах эцсийн хугацаа: Огноо: 2025 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Цаг: 17 цаг 00 минутаас өмнө <u>битүүмжилсэн</u> хэлбэрээр ирүүлэх.
3. Сонгон шалгаруулалтын саналыг бэлтгэх	
1	Сонгон шалгаруулалтын хэл: Монгол хэл
2	Дотоодын давуу эрхийн зөрүү: Тооцохгүй

3	Гадаадын этгээдийн оролцох эсэх: Эрхгүй
4	Хувилбарт үнийн санал ирүүлэхийг зөвшөөрөх эсэх: Зөвшөөрөхгүй
5	Үнийн саналын хүчинтэй байх хугацаа: Үнийн санал нээснээс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6	Үнийн саналын валют: Төгрөг
7	Үнийн санал: Үнийн саналыг сонгон шалгаруулалтын бичиг баримтын хамт ирүүлнэ
8	Үнийн саналын дэлгэрэнгүй: Сонгон шалгаруулалтын багц тус бүрээр, тоног төхөөрөмж, хэрэгслийн дэлгэрэнгүй үнийг бэлтгэн ирүүлнэ. НӨАТ, суурилуулалт сургалтын зардал багтсан байна.
9	Календарчилсан төлөвлөгөө: Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх хуваарь, суурилуулалт, сургалт зохион байгуулах
10	Сонгон шалгаруулалтад оролцох оролцогчийн бэлтгэж ирүүлэх бичиг баримтын бүрдэл: Сонгон шалгаруулалтад оролцогч нь өөрийн бүх бичиг баримт, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна. Захиалагчийн сонгон шалгаруулалтын өгөгдөлд заасан бүх нөхцөл, шаардлагыг нэгэн зэрэг хангаж байгаа, түүнд заасан баримт бичиг, үнийн санал илгээх болон бусад маягтуудыг зохих ёсоор ирүүлээгүй тохиолдолд сонгон шалгаруулалтаас татгалзах үндэслэл болно.
	4. Сонгон шалгаруулалтад үнийн санал ирүүлэх
1	Үнийн санал хүлээн авах захиалагчийн хаяг: Японы Хүүхдийг Ивээх Сангийн төв оффис, Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Аризона төв, 4-р давхар Лавлах утас: 976-11-329365-(131)
2	Сонгон шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор үнийн саналын гаднах дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: Сонгон шалгаруулалтын нэр: Завхан аймгийн Түдэвтэй, Говь-Алтай аймгийн Чандмань сумдын Эрүүл мэндийн төвүүдэд мобайл технологийн аппарат, тоног төхөөрөмжийн иж бүрдэл, техник хэрэгсэл нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Сонгон шалгаруулалтын багцын талаарх мэдээлэл: Багц 1. Говь-Алтай аймгийн Чандмань сумын эрүүл мэндийн төвд мобайл технологийн аппарат, тоног төхөөрөмжийн иж бүрдэл, сумын ЕБС-н эрүүл мэндийн хичээлийн хэрэглэгдэхүүн нийлүүлэх Багц 2. Завхан аймгийн Түдэвтэй сумын Эрүүл мэндийн төвд иж бүрэн шүдний кабинет техник хэрэгслийн хамт нийлүүлэх Багц 3. Архангай аймгийн Тариат сумын эрүүл мэндийн төвд хагас автомат биохимийн анализатор нийлүүлэх. Сонгон шалгаруулалтын дугаар: SCJT-01/25 Сонгон шалгаруулалтад оролцогч нэр хаяг, утсаа тодорхой гаргацтай бичнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1	Гэрээнд гарын үсэг зурах: Гүйцэтгэгчээр шалгарсан оролцогч нь гэрээ байгуулах тухай мэдэгдсэнээс хойш ажлын 3 өдөрт багтааж гэрээг байгуулна.
2	Ажил эхлэх өдөр: Гэрээ байгуулсан өдөр, огноогоор тооцно.
3	Татвар, даатгал хураамж: Гүйцэтгэгч бүрэн хариуцна.
4	Төлбөрийн нөхцөл: Урьдчилгаа санхүүжилт: Гэрээ зурагдсаны дараа 40%

	<p>Дунд шатны санхүүжилт: Тоног төхөөрөмж хүлээн авч дууссаны дараа 40%</p> <p>Эцсийн санхүүжилт: Суурилуулалт хийгдэж, сургалт зохион байгуулан Сумдын эрүүл мэндийн төвүүдийн эрх бүхий этгээдүүд бүрэн хүлээн авч хүлээлцэх акт зурагдаж сургалтын тайлан хүлээн авсны дараа үлдэгдэл 20%</p> <p>Төлбөр хийх хугацаа: Төлбөрийн мэдэгдэл гарсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан санхүүжилтийг хийнэ.</p>
5	Чанарын баталгаа шаардах эсэх: Үгүй
6	Баталгаат хугацаа: Тоног төхөөрөмж, шаардлагатай техник хэрэгсэл тус бүрээр баталгаат хугацаа болон доголдол арилгах мэдээллийг ирүүлнэ.
7	<p>Гүйцэтгэгчийн төлөх Алданги</p> <p>Алданги тооцох эсэх: Тийм</p> <p>Алдангийн хувь: Хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувь байна.</p> <p>Захиалагчийн төлөх Алданги:</p> <p>Алданги тооцох эсэх: Тийм</p> <p>Алдангийн хувь: Хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувь байна.</p> <p>Алдангийн нийт дүн: 50 хувиас хэтрэхгүй байх</p>
8	Гэрээний үнэ: Гэрээний үнэд тохируулга хийхгүй гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна.
9	<p>Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:</p> <p>Шаардлага хангасан тоног төхөөрөмжийг тенхикийн тодорхойлолтын дагуу хүлээн авна.</p> <p>Бараанд холбогдох баримт бичиг: Зарлагын баримт, техникийн паспорт, баталгааны хуудас, ажил хүлээлцэх акт,</p> <p>Угсралт, суурилуулах: Завхан аймгийн Түдэвтэй сумын эрүүл мэндийн төв, Говь-Алтай аймгийн Чандмань сум, Архангай аймгийн Тариат сумын эрүүл мэндийн төв</p>

БҮЛЭГ 2. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Багц 1. Говь-Алтай аймгийн Чандмань сумын эрүүл мэндийн төвд мобайл технологийн аппарат, тоног төхөөрөмжийн иж бүрдэл, сумын ЕБС-н эрүүл мэндийн хичээлийн хэрэглэгдэхүүн нийлүүлэх

1. ЗӨӨВРИЙН МОБАЙЛ ТЕХНОЛОГИЙН АППАРАТ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ИЖ БҮРДЭЛ

Баталгаат хугацаа: 12 сар болон түүнээс дээш. Баталгааны хугацаанд засвар үйлчилгээг ямар хугацаанд шийдвэрлэх мэдээлэл оруулна.

Доголдол: Үйлдвэрийн доголдолтой барааг нийлүүлэгч тал хариуцаж сольж доголдлыг арилгана
Хүлээж авах байршил: Бүтээгдэхүүн нийлүүлэгч байгууллага Говь-Алтай аймгийн Чандмань сумдын Эрүүл мэндийн төвд хүлээлгэн өгч суурилуулалт хийн сургалт зохион байгуулах ба сумын ЕБС.

Бичиг баримт: Бүтээгдэхүүний гэрчилгээ паспорт заавал хүлээлгэн өгнө. Ашиглалтын заавар, гарын авлага баталгааны хуудас монгол хэл дээр байна. Мөн техникийн гэрчилгээг хавсаргана.

1. Мобайл Эхо	
Тоо ширхэг	1
Скан хийх горим:	Хэт авианы
Үзэх горим:	B, B / M, өнгөт доплер хувилбар B + Өнгө, B + PDI, B + PW
Пробын элемент:	80/128/192
RF-ийн үзэх суваг:	16/32/64
Давтамж, сканнердах гүн, толгойны өргөн	
Шугаман:	7,5мГц/10мГц, 20/40/60/ 100мм, 40мм
Гүдгэр:	10мГц/14мГц, 20/30/40/ 55мм, 25мм
Зургийн тохируулга	BGain, TGC, DYN, Focus, Гүн, Гармоник, Denoise, Color Gain, Steer, PRF
Пунктурын функц	Чиглүүлэгч шугамын функц, автоматаар цусны судсыг мэдэрнэ
Мэдрэх утга:	Уртын аргаар, талбайн аргаар, өнцгөөр, зүрхний цохилт, Эх барихын
Зураг хадгалах өргөтгөл:	jpg, avi, DICOM формат
Зураг дамжуулах хурд	18frame/сек
Батарейны ажиллах хугацаа:	3-5 цаг
Хэмжээ :	156±50мм *60±30мм*20 мм
Жин:	200-250гр
Wifi төрөл:	802.11 g / 20 MHz / 5G / 450 Mbps
Ажиллах үйлдлийн систем:	Android, Windows
Дагалдах хэрэгсэл:	Таблет: wifi болон 5G сим дэмждэг байх, Дэлгэцийн хэмжээ 10-11 инч, багтаамж: 128GB, RAM:8GB урд камер: 8-16 мегапиксель, ард 24 мегапиксель ба түүнээс дээш байх, автофокус, Батарей: 5100 mAh-

	<p>8800 хүртэл байх, 2023 оны хойш үйлдвэрлэгдэж гарсан загвар байх.</p> <p>*Зөөврийн хэт авианы шинжилгээг хийхэд ашиглагдах аппликейшныг суулгасан. Шууд ашиглах бүрэн боломжтой байх.</p> <p>Хэрэв нийлүүлэгч компани зөөврийн хэт авианы шинжилгээний аппаратыг нийлүүлэхдээ таблетгүйгээр нийлүүлэх бол зайлшгүй дагалдах аппликейшныг дагалдуулан худалдаах ба бусад компаниас худалдан авсан таблет-д аппликейшныг суулгаж хэт авиа аппаратын ажиллагааны бүрэн бүтэн байдлыг хангаж өгнө.</p>
--	---

2. Зөөврийн Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат (ЭКГ)	
Тоо ширхэг	1
Суваг	Нэг сувгийн ЭКГ хяналт
Электродууд	3 кабелийн холболттой
Дэлгэц	2,8-3,2 өнгөт LCD дэлгэц, хэмжээ 240*160 мм
Зүрхний цохилтын давтамж	30-240 цагийн хооронд
Зүрхний цохилтын нарийвчлал	±2 мин
Долгионы мэдрэг байдал	5,0мм/мВ
Хэмжилт хийх хурд	20мм/с-25 мм/с
Хэмжилт хийх хугацаа	30 секунд
Мэдээлэл хадгалах	300-400 pcs долгион хэлбэр
Мэдээлэл хуулах	Хэмжилт хийсэн утгыг гар утас, таблет, зөөврийн компьютерт хуулах бүрэн боломжтой Bluetooth,USB оролт, C-type, USD, microUSD аль нэг заавал байх
Хэмжээ	125*70*21,5мм ± 50мм
Батарейны ажиллах хугацаа:	Дахин цэнэглэх боломжтой, зөөврийн байх, Эсвэл AAA батарейгаар ажиллах боломжтой байх
Жин:	106гр ± 100гр

3. Даралтын аппарат	
Тоо ширхэг	1
Онцлог байдал	Ухаалаг гар утас, таблет, зөөврийн компьютер дэмжин ажилладаг байх, Сүүлийн 100-200 удаагийн хэмжилтийг гар утас, таблет, зөөврийн компьютер руу дамжуулан хяналтыг хийх боломжтой байх
Холболт	Wireless, Bluetooth V 3.0

Манжета диаметр	22-45 см хүртэл байх
Хэмжих аргачлал	Осциллометр автомат, нарийвчлалтай хэмжүүр
Чадал	5 В, 0.1 А, 13.7 В 400 мА батарей
Манжатакны даралтын хязгаар	0-295 мм м.у.б
Хэмжилтийн алдаа	± 3 мм.м.у.б
Пульс хэмжээ	40-180 минутанд цохилох тоо

4. Холестерин хэмжигч	
Тоо ширхэг	1
Онцлог байдал	Зөөврийн, жижиг өврийн байх
Мэдрэгч	Электрохимийн биосенсор
Хэмжих хугацаа	10-20 сек
Дээжийн эзлэхүүн/хэмжээ	0,7-10
Хэмжилтийн хязгаар	20-60 мг/дЛ (1.1~33.3 ммол/Л)
Хэмжилтийн хязгаар	100-400 мг/дЛ (2.59~10.35 ммол/Л)

5. Глюкометр аппарат	
Тоо ширхэг	1
Онцлог байдал	Зөөврийн, жижиг өврийн байх
Санах ой	Сүүлийн 20-50 удаагийн хэмжилтыг хадгалж санадаг байх
Хэмжих хугацаа	5-10 сек
Дээжийн эзлэхүүн/хэмжээ	0,7
Хэмжилтийн хязгаар	Хэмжилтийн хязгаар: 20-600 мг/дЛ (1.1-33.3 ммол/Л)
Батарей	Цэнэглэдэг эсвэл батрей ажилладаг байх
Жин	29гр ± 10гр
Дэлгэц	Дижитал дэлгэц эсвэл LCD
Тестер	Элбэг олдцотой байх

Говь-Алтай аймгийн Чандмань сумын ЕБС-д эрүүл мэндийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн

Баталгаат хугацаа: 12 сар болон түүнээс дээш. Баталгааны хугацаанд засвар үйлчилгээг ямар хугацаанд шийдвэрлэх мэдээлэл оруулна.

Доголдол: Үйлдвэрийн доголдолтой барааг нийлүүлэгч тал хариуцаж сольж доголдлыг арилгана

Хүлээж авах байршил: Говь-Алтай аймгийн Чандмань сумын ерөнхий боловсролын сургууль

Бичиг баримт: Бүтээгдэхүүний гэрчилгээ заавал хүлээлгэн өгнө. Ашиглалтын заавар, гарын авлага баталгааны хуудас монгол хэл дээр байна.

6. Амилуулах суурь тусламжийн сургалтад насанд хүрэгчийн ашиглах муляж	
Тоо ширхэг	1
Техник үзүүлэлт	Хэмжээ: Насанд хүрэгчдийн биетэй жишихүйц цээжин бие
	Зүрхний иллэгийн хурд болон даралтыг тодорхойлдог индикатортай байх
	Амилуулах суурь тусламжийг үлгэрчлэн хийх, хиймэл амьсгал өгөх ашиглагдах барьер масктай 1 хайрцаг байх
	Угааж цэвэрлэх боломжтой гадаргуутай байх
	Амьсгалын зам нээх, амьсгал өгөх боломжтой байх
	Цэнэглэдэг эсвэл батарей ажилладаг байх
	Цээж шахалтын гүн 5-6см хийх боломжтой байх
	Багцад багтах бүрдэл хэсгүүд: Толгой, их бие, уушги, цүнх, маск
	Механик(гар) цээж шахалтын хэмжих, 30 шахалт:2 хиймэл амьсгалын хэмжих эргэлтийн хугацаа болон харьцааг тодорхойлох индикатор гэрэлтэй байх
	Багадаа 1 минутад 100 шахалтыг тодорхойлох боломжтой байх <ul style="list-style-type: none"> - Динамик гэрлийн индикатортай байх: жишээ нь цээжний шахалтын гүн 5-6 см байхад ногоон гэрэл асах, 5-с доош байхад шар гэрэл асах, 6 см дээш байхад улаан гэрэл асаж сануулах гэх мэт индикатортай байх. - цээж шахалтын тоог харуулах дижитал тоологчтой байх. - Хиймэл амьсгал хийх, амьсгалын зам чөлөөлөх, амтай байх - хиймэл амьсгалыг 500-600мл-1000 мл өгөхөд (зөв өгч байгааг илтгэх индикатор гэрэл эсвэл цээж өргөгдөж, тэлж байгаа харагдах боломжтой байх)

7. Амилуулах суурь тусламжийн сургалтад хүүхдийн муляж	
Тоо ширхэг	1
Техник үзүүлэлт	Хэмжээ: 1 нас хүртэлх хүүхдийн биетэй жишихүйц бүтэн бие
	Зүрхний иллэгийн хурд болон даралтыг тодорхойлдог индикатортай байх
	Амилуулах суурь тусламжийг үлгэрчлэн хийх, хиймэл амьсгал өгөх ашиглагдах барьер масктай 1 хайрцаг байх
	Угааж цэвэрлэх боломжтой гадаргуутай байх
	Амьсгалын зам нээх, амьсгал өгөх боломжтой байх
	Цэнэглэдэг эсвэл батарейгаар ажилладаг байх
	Багцад багтах бүрдэл хэсгүүд: Толгой, их бие, уушги,

	<p>цүнх, маск</p> <p>Механик(гар) цээж шахалтын хэмжих, 30:2 эсвэл 15:2 цээж шахалт, хиймэл амьсгалын хэмжих эргэлтийн хугацаа болон харьцааг тодорхойлох индикатор гэрэлтэй байх</p> <p>Багадаа 1 минутад 100 шахалтыг тодорхойлох боломжтой байх.</p> <ul style="list-style-type: none"> - Динамик гэрлийн индикатортай байх: жишээ нь цээжний шахалтын гүн 4-5 см байхад ногоон гэрэл асах, 4-с доош байхад шар гэрэл асах, 5 см дээш байхад улаан гэрэл асаж сануулах гэх мэт индикатортай байх. - Цээж шахалтын тоог харуулах дижитал тоологчтой байх. - Хиймэл амьсгал хийх, амьсгалын зам чөлөөлөх, амтай байх - Хиймэл амьсгалыг 500-600мл-1000 мл өгөхөд (зөв өгч байгааг илтгэх индикатор гэрэл эсвэл цээж өргөгдөж, тэлж байгаа харагдах боломжтой байх)
--	---

Багц 2. Завхан аймгийн Түдэвтэй сумын Эрүүл мэндийн төвд иж бүрэн шүдний кабинет техник хэрэгслийн хамт нийлүүлэх

ШҮДНИЙ ЭМНЭЛГИЙН ИЖ БҮРЭН КАБИНЕТЫН ТЕХНИК ХЭРЭГСЭЛ

Баталгаат хугацаа: 12 сар болон түүнээс дээш. Баталгааны хугацаанд засвар үйлчилгээг ямар хугацаанд шийдвэрлэх мэдээлэл оруулна.

Доголдол: Үйлдвэрийн доголдолтой барааг нийлүүлэгч тал хариуцаж сольж доголдлыг арилгана.

Хүлээж авах байршил: Завхан аймгийн Түдэвтэй сумын эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмжийн хүргэлт суурилуулалт үнийн саналд оруулж тооцно.

Бичиг баримт: Бүтээгдэхүүний гэрчилгээ паспорт заавал хүлээлгэн өгнө. Ашиглалтын заавар, гарын авлага баталгааны хуудас монгол хэл дээр байна.

ШҮДНИЙ ЭМНЭЛГИЙН ИЖ БҮРЭН КАБИНЕТЫН ТЕХНИК ХЭРЭГСЭЛ			
	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэмэлт тайлбар
1	Эмчилгээний иж бүрэн сандал/ бор машин/	1 ком	<ul style="list-style-type: none"> · Автомат удирдлагатай, ОУ-ын стандарт шаардлагад бүрэн нийцсэн ажиллагаа нь хялбар, шүдний орчин үеийн эмнэлэгт зориулагдаж бүтээгдсэн. · 2022 оноос хойш үйлдвэрлэгдсэн. · Шүдний эмчилгээ хийхэд зориулагдсан өрмүүдийн холбогч, лед гэрэл, шүлс хүчтэй соруулагч төхөөрөмж, 3 замын шахуургатай · Рентген зургийн дэлгэц, хөл педаль, усан болон агаарын урсгалын системтэй · Oral camera болон зориулалтын LCD дэлгэцээр тоноглогдсон · Шүлс хаях савтай /шаазан/ · Туслагчийн хяналтын тавиуртай · Шүдний сандал /агаар, ус, цахилгааны асаагуур/ · Ажилбарын тавиуртай · Агаарын даралтын хэмжигчтэй · Өрөм байрлуулах нүхнүүдтэй · Хянах самбартай · Эмчийн дугуйтай сандалтай байх(1ш) · Сувилагчийн дугуйтай сандалтай байх(1ш) · Цахилгаан хүчдэл 220В/50Гц · Чадал 800VA · Ам зайлах усны температур 40±5°C · Шүдний сандлын ажиллах цаг/интервал≤60% · Турбины эргэлтийн дээд хурд ≥300,000эрг/мин · Моторын эргэлтийн доод хурд 20,000эрг/мин · Агаарын даралт үүсэх 0,55-0,6МПА · Усны даралт үүсгэх 0,2-0,4МПа · Орчны температур 5-40°C · Амны хөндийн USB камер, зургийн нягтрал HD /led 17инч/ амны хөндийн дэлгэцийг

			<p>шүдний машинд суурилуулсан</p> <ul style="list-style-type: none"> · Мэдрэгчтэй ЛЕД гэрэлтэй · Чулуу авагч суурилуулсан · Сандлын даац: 130кг-с багагүй · 3ш наконечниктэй (2ш хурдан эргэлтэт, 1ш удаан эргэлтэт) · Тахир болон шулуун цагаан гартай · Хөл удирдлагатай · Хурдны бууруулагч цахилгаан мотор · Ашиглах гарын авлагыг монгол хэл дээр
2	Сувгийн хэмжигч	1	Адаптер ажиллах хүчдэл 100-240Vac, 50/60HZ шингэнтэй үед сувгийн уртыг хэмжих боломжтой хурдны тохируулгатай эргэлтийн хурдыг дэлгэцэн дээр хэмждэг, санадаг
	Зөөврийн хурдан эргэлтэт машин	1	Стандартад нийцэхүйц
3	Гэрлийн аппарат/ ломбо хатууруулагч/	1	ХАМГИЙН БАГАДАА: Суурин цэнэглэгчтэй, зөөврийн 220Вт р цэнэглэдэг баттерейтай, гэрлийн ломбыг 10 секундэд хатаах үйлчилгээтэй, Гаралтын U.I: 4.2В, 1500мА, 8мм гэрлийн чиглүүлэгч хоолой, литион баттерей, цэнэглэгч, тэжээлийн блок, гэрлийн хамгаалалттай
4	Компрессор /бор машины/	1	Дуу чимээ багатай, 220Вт, 50гц ажилладаг
5	Шүдний рентген, сенсор	1	<p><u>Шүдний Рентген “ХАМГИЙН БАГАДАА”</u></p> <ul style="list-style-type: none"> - Тусгалын цэг 0.4 мм (IEC 60336) - Хоолойн хүчдэл (кВ) 65 кВ - Хоолойн гүйдэл (мА) 3.0 мА - Зураг авах хугацаа 0.05 ~ 0.5 сек - Ерөнхий шүүлтүүр Мин. 1.5 мм Al - Хамгаалагч хошууны урт мм 150, 200 - Рентген туяаны тусгалын талбай Үндсэн: 60 мм дугуй Нэмэлтээр: , 30 x 40 мм ,20 x 30 mm тэгш өнцөгт - Жин 1.4 кг -с ихгүй Сенсор “ХАМГИЙН БАГАДАА” Пикселийн хэмжээ: 29,6мм Нягтрал: 17lp/mm Динамик хүрээ: 12бит Мэдрэгчийн хэмжээ /өр*ур/ а. 1.0_20x30mm; б. 1.5_24x33mm; в. 2.0_26x36mm Хэмжээ /өр*ур*зу/ Хэмжээ 1.0 _ 25.4 x 36.8 мм (1.00 X 1.45 инч) Хэмжээ 1.5 _ 29.2 x 39.5 мм (1.14 X 1.55 инч) Хэмжээ 2.0 _ 31.3 x 42.9 мм (1.23 X 1.69 инч) Зузаан 4,8мм /0,19 инч/ Кабелийн урт 2,7м

6	Шүдний өрмийн бариул ариутгагч автоклав	1	Хүчин чадал: 1,8л Ариутгалын ангилал: В 220В ажилладаг 50/60GZ давтамжтай Дээд Нр: 1100, Багтаамж: 1.0-1.5л, Ариутгагч температур 121°C,134°C, Хатаах үйл явц: гүйцэд Дижитал дэлгэц Цэвэрлэх үйл явц: Хоолой болон уурын генераторын доторх автомат цэвэрлэгээ Даралт, температур тэжээлийн ачаалал, эвдрэлийн дохиолол, дуусгах сануулга, усны түвшний анхааруулгатай
7	Багаж пакетлах, наагч	1	Ороосон цаасаа өөр дээрээ тогтоогчтой, автомат тастагчтай, овор хэмжээ багатай
8	Ус нэрэгч	1	Багтаамж: 5л Цахилгаан хүчдэл: 220В Халаах чадал: 4,5кв Ус нэрэх хэмжээ: 5л/цаг
9	Кварцтай багаж хадгалах шүүгээ	1	220 Вт, 50гц-р ажилладаг, ариун багажийг хатаах болон кварцын хос үйлдэлтэй, 60*60*40-с дээш хэмжээтэй, Багтаамж 150л-аас багагүй Температурын хэлбэлзэл: 5 ⁰ -350°C Халаах чадал: 3кВт Тавиурын даац: 5кг-с дээш
10	Кварцын гэрэл	1	10-50м2 талбайг халдваргүйжүүлнэ.
11	Хурдан эргэлтэт өрмийн хошуу	5	Стандартад тохирох
12	Зориулалтын тэргэнцэр	1	85х65х44 2-3тавиур, 1-2 шургуулга, хувинтай, хуванцар материал/никель, дугуйтай
13	Удаан эргэлтэт өрмийн хошуу	1	Стандартад тохирох
14	Үзлэгийн толь	25	Олон улсын стандартын шаардлага хангасан түүнтэй дүйцэхүйц Зэвэрдэггүй ган материалтай, угааж цэвэрлэх болон дахин хэрэглэх боломжтой байх Ариутгалын уусмалд тэсвэртэй.
15	Шүдний зонд	25	
16	Хямсаа	25	
17	Экскаватор	30	
18	Гладилка	30	
19	Штопфер	30	
20	Элеватор /тахир 2 талт/	18	

21	Элеватор шулуун	18	
22	Шүдний бахь /том хүний/	30	Хоншоор үүдэн бүлэг шүдний-5ш хоншоор баруун соёо - 1ш, хоншоор зүүн соёо-1ш хоншоор баруун бага араа 1ш , хоншоор зүүн бага араа-1ш хоншоор баруун их араа-1ш хоншоор зүүн их араа-1ш хоншоор ёзоор- 1ш хоншоор агт араа-1ш Араа бүлэг шүдний баруун-2 ш Араа бүлэг шүдний зүүн-1 ш Эрүү үүдэн бүлэг шүдний баруун-1 ш Эрүү үүдэн бүлэг шүдний зүүн-1 ш Эрүү соёо баруун -1ш Эрүү соёо зүүн-1ш Эрүү бага араа баруун-1 ш Эрүү бага араа зүүн-1ш Их араа баруун-1 ш Их араа зүүн -2 ш Эрүү ёзоор -1 ш Эрүү агт араа-1 ш Их араа баруунаас-2 ш Их араа зүүнээс-1 ш
23	Шүдний бахь /хүүхэд/	14	Хоншоор үүдэн бүлэг – 4 ш Баруун араа - 2 ш Зүүн зүүн араа – 2 ш Эрүү үүдэн бүлэг шүд- 2 ш Араа бүлэг баруун-2 ш Араа бүлэг зүүн-2 ш
24	Бөөрөн таваг	5	Төмөр
25	Хэл дарагч	18	Төмөр
26	Зүү баригч	5	Оёдол тавихад хэрэглэгддэг
27	Хар зүү	100	Стандартад нийцэхүйц
28	Эмийн хундага	10	шилэн
29	Тариур	15	Олон улсын стандартын шаардлага хангасан түүнтэй дүйцэхүйц Зэвэрдэггүй ган материалтай, угааж цэвэрлэх болон дахин хэрэглэх боломжтой байх Ариутгалын үүсмалд тэсвэртэй.
30	Материал зуурах шпатель	10	төмөр
31	Мэс заслын хутга	10	скалпел
32	Чулууны аппарат	1	220В, 50Гц, 1А. Усны даралт: 138-275Па, усны температур 25 ⁰ С—с бага, Усны урсгалын хурд min>15ml/min, Цахилгаан кабелийн урт 1,5-м с дээш, Усны шугамын урт 4м, утасгүй хөл педалтай
33	Чулуу авагч хошуу	20	Стандартад нийцэхүйц

34	Үзлэгийн багаж нэг удаагийн	1000	хуванцар
35	Зажем	10	14см-5 ш, 8см-5ш
36	Алмаазан бор	70	Бөөрөнхий хэмжээ тус бүр 20ш, Конус/писсурный-10ш, дусал-30 ш, трапец 10ш
37	Өнгөлгөөний резин	30	Стандартад нийцэхүйц
38	Суваг дүүргэгч	70	Хуруун 50, цахилгаан 50
39	Зөөлц авагч	30	Стандартад нийцэхүйц
40	К файл, Н файл, Ример №15-№40 /Том хүний/	108	№15-№40 тус бүр 6
41	К файл, Н файл, Ример №15-№40 /Хүүхдийн/	108	№15-№40 тус бүр 6
42	Эндо Орал Камер	1	АС220V цахилгаан эсвэл АС24 тэжээлийн хангамжтай, Шилэн лацтай ус нэвтрүүлдэггүй, уур нэвтрүүлдэггүй, Нягтрал 1280 X 720 Pixels болон түүнээс дээш

Багц 3. Архангай аймгийн Тариат сумын эрүүл мэндийн төвд хагас автомат биохимийн анализатор нийлүүлэх.

Баталгаат хугацаа: 12 сар болон түүнээс дээш. Баталгааны хугацаанд засвар үйлчилгээг ямар хугацаанд шийдвэрлэх мэдээлэл оруулна.

Доголдол: Үйлдвэрийн доголдолтой барааг нийлүүлэгч тал хариуцаж сольж доголдлыг арилгана.

Хүлээж авах байршил: Архангай аймгийн Тариат сумын эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмжийн хүргэлт суурилуулалт үнийн саналд оруулж тооцно.

Бичиг баримт: Бүтээгдэхүүний гэрчилгээ паспорт заавал хүлээлгэн өгнө. Ашиглалтын заавар, гарын авлага баталгааны хуудас монгол хэл дээр байна.

Үзүүлэлт	Нарийвчилсан үзүүлэлт	Шаардлага
Ерөнхий үзүүлэлт	Хүчин чадал	Цагт 200 үзүүлэлт
	Аналитик метод	End-point, Fixed time, Kinetic, Turbi
	Сертификат	CE, ISO9001, ISO13285
Сорьц уусмалын үзүүлэлт	Сорьц байрлуулалт	37 Сорьц зэрэг тавих боломжтой
	Уусмал байрлуулалт	28 уусмал байрлуулна
	Сорьц сорох хэмжээ	2-70ul
	Уусмал сорох хэмжээ	20-350ul
	Зүү	Соронзон бүрээс, хэмжээ мэдрэх функц
	Зүү угаалт	Зүү гадаад дотоод автомат угаалт
	Уусмал хөргөлт	Тусдаа удирдлага бүхий хөргүүр
Урвалын систем	Температур контрол	37 градус
	Кувет	Дахин ашиглах боломжит 48 кувет
	Зүү холигч	Хутгагч
	Угаалт	Автомат кувет угаагч
	СТАТ функц	Yes
Оптик систем	Гэрлийн хүч	6V/30W галоген ламп
	Сфектофотометр	
	Нанометр	340, 405, 450, 480, 505, 546, 570, 600, 630, 700, 750, 800nm
	Авсорбенс	0-3.0 Abs
Калибратор контрол	Калибратор	Фактор, 1,2 болон олон цэгийн стандарт, Spline Polygen
	Чанарын хяналт	Real time, Westgard rule, daily QC, Monthly QC
Дата менежмент	Программ	Windows 7/8/10
	LIS систем	HL7 протокол
	Холболт	LAN port холболт
	Принтер	Холболтоор
Ажиллах нөхцөл	Тог залгуур	220V 50/60Hz
	Температур	15-20 градус
	Ус	Цагт 5 литр
	Чийгшил	40%-85%
Хэмжээ өндөр	Хэмжээ	625*425*460mm
	Өөрийн жин	36кг

Савлагаа	1130*735*1040mm
Хайрцагтай жин	55 кг

БҮЛЭГ 3. МАЯГТУУД

МАЯГТ 1

Сонгон шалгаруулалтад илгээх маягт

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай **[оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад **[үнийн хөнгөлөлт тооцоогүй сонгон шалгаруулалтын үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бараа эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү сонгон шалгаруулалтад (цаашид “**сонгон шалгаруулалт**” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөлтэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Шалгаруулалттай холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Шалгаруулалтад үнийн хөнгөлөлт **[“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].**
5. Шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[ажлын 30 ба түүнээс дээш хоногийн тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Шалгаруулалтад санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, шалгаруулалтыг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]: Хаяг:

МАЯГТ № 2

ИТГЭМЖЛЭГДСЭН БИЧИГ

Энэхүү үнийн саналын бичиг баримтад гарын үсэг зурагч _____ компанийн
_____ ажилтай _____ овогтой _____ нь _____ компна
нийн

нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн
тул _____-ын дор зурсан гарын үсгийг баталгаажуулж байна.

_____ нь _____ компанийг
төлөөлж _____ компанийн нэр дээр гэрээ, хэлцэл байгуулах, ажил
эхэлж дуусгах, гүйцэтгэл гаргах, гологдлыг барагдуулах, албан бичиг баримт явуулах зэрэг сонгон
шалгаруулалтад холбогдолтой бүх материалд гарын үсэг зурах эрхтэй болно.

Энэхүү итгэмжлэх бичгийг гэрчилж 2022 оны ____ дугаар сарын ____ ны өдөр гарын үсэг зурав.

Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн:

Тэмдэг

Овог, нэр _____

Гарын үсэг _____

Баталгаажуулагчийн

Албан тушаал: _____

Овог, нэр _____

Гарын үсэг _____

СҮҮЛИЙН 2 ЖИЛ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Төсөл/Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас	Гүйцэтгэсэн хугацаа (дууссан, хугацаа)	Гэрээний үнэ (сая.төг)	Хавсаргасан материалын жагсаалт

